**МОНГОЛ УЛСЫН**
**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ**
**САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 04 сарын 15 өдөр        Дугаар 128        Улаанбаатар хот

Гадаадад сургалтын төрийн сангийн
зээлээр суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн Монгол Улсын их сургуулийн багш нарын чадавхийг дээшлүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар Монгол улсын их сургуулийн багш Нацагдоржийн Энхжаргалыг АНУ-ын Орегоны их сургуулийн докторантурт Газар зүйн мэдээллийн чиглэлээр 3 жилийн, Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургуулийн багш Мажигсүрэнгийн Мөнгөнхуягийг Япон Улсын Токушима их сургуулийн докторантурт Дүрс оношлогооны чиглэлээр 3 жилийн хугацаатайгаар суралцуулсугай.

2. Суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД        Ё.ОТГОНБАЯР

D:\STS\tushaal\HS